



## **Шивээговь сумын Соёлын танилцуулга**

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Соёлын төв нь анх 1989 оноос үүсгэн байгуулагдаж 1995 он хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад 1995 онд татан буугдсан. 1995 оноос 2002 он хүртэл сумын нийгмийн бодлогын ажилтан соёлын үйл ажиллагааг гүйцэтгэдэг байж байгаад, 2002 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Сумын “Соёлын төв” нэртэйгээр улсын бүртгэлд бүртгэгдэн Ж.Мир эрхлэгчтэйгээр сумын ЗДТГын зүүн жигүүрийн өрөөнүүдийг нэгтгэн засварлаж түрээслэн албан ёсоор үүд хаалгаа нээж соёл урлагын үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

### **СОЁЛЫН ТӨВИЙН ҮЕ ҮЕИЙН ЭРХЛЭГЧ НАР**

1989-1992 онд Ч.Сүрэнжав

1994-1995 онд Цэрэндолгор

2002-2005 онд Ж.Мир

2005-2008 онд У.Санчирмаа

2008-2009 онд Г.Булганхангай

2009,12 сараас-2010,07 сар хүртэл Б.Аасүрэн

2010 оны 10 сараас одоог хүртэл Э.Төрмандах ажиллаж байна.

Соёлын төв нь өнөөдрийн байдлаар эрхлэгч Э.Төрмандах, бүжгийн багш Л.Түмэнцэцэг, номын санч Ш.Буяннэмэх, ОНСТ-ын ажилтан Э.Сувдмаа, үйлчлэгч З.Гантуяа гэсэн 5 орон тоотойгоор сумын хэмжээнд ард иргэдийг соёлын иж бүрэн үйлчилгээгээр хангах, соёлыг хүртээмжтэй

чанартай, тогтмол уян хатан хүргэх арга хэмжээг баримтлан ажил үйлчилгээгээ явуулж байна.

Соёлын төв нь 150 хүний суудал бүхий заалтай, дэргэдээ нийтийн номын сан, орон нутаг судлах танхимтай, бүжгийн “Шивээн ганхаа 1, 2, 3, 4,5” хамтлагтай. Бүжгийн дугуйлан 150 гаруй хүүхэд багачуудыг хамруулан үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Манай байгууллага нь соёлын үйлчилгээг ард иргэдэд тасралтгүй түгээн дэлгэрүүлж ажиллах хугацаандаа **нийт 5 МУСТА, 18 МУТАА, 6 ҮЭСТА** нарыг тодруулсан. Үүнээс сүүлийн 3 жилийн хугацаанд **МУСТА 3, МУТАА 5, ҮЭСТА 6** хүн тус тус шагнагдсан байна. Сумын шилдэг байгууллагаар 2012 онд шалгарсан. 2014 онд “Хүүхдийн авъяасыг дэмжигч байгууллага”-аар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын өргөмжлөл хүртсэн.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжилт “Боржигин түмний дуулал” 2016 урлагийн наадмын 2-р байр мөн “Боржигин түмний дуулал” 2018 оны урлагийн наадмын тэргүүн байрыг тус тус эзэлсэн.

2017 онд ҮЭ-ийн 100 жилийн ойн улсын урлагийн наадамд соёлын төвийн дэргэдэх “Хүрд” цахилгаан хөгжмийн хамтлаг 3-р байр, уран уншлага тэргүүн байрыг тус тус эзэлсэн.

Соёлын төвийн дэргэдэх Шивээн ганхаа 1,2,3,4,5 хамтлагийг бүжгийн багш Л.Түмэнцэцэг 2011 оны 07 сарын 03-ны өдөр анх үүсгэн байгуулсан. Тус хамтлагийн хүүхдүүд нь ХБК-ийн ардын болон сонгодог бүжгийн анги, СУИС-ийн Бадмаараг лицей дунд сургуулийн бүжгийн ангид нийт 23 хүүхэд тус тус элсэн суралцдаг. Тус хамтлаг нь улс, аймаг орон нутгийн уралдаан тэмцээнүүдэд дараах амжилтуудыг үзүүлээд байна.

Нийт ОУ-ын, улсын, бүсийн, орон нутгийн чанартай 73 тэмцээн уралдаанд **оролцож 58 хувь нь тэргүүн байр 13 хувь нь дэд байр 29 хувь нь гутгаар байр тус тус эзэлсэн үзүүлэлттэй** байна.



Соёлын төв нь 2012 оноос хойш орон нутаг судлах танхимыг байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт 8 чихмэл амьтад, 16 эд өлгийн

үзмэртэйгээр орон нутгаа сурталчилан таниулах ажлыг хийж байна. Мөн сумын хэмжээний ардын язгуур урлаг, уламжлалт гар урлал, эх хэл аман уламжлал, зан үйл, ёслол баяр зэргийг өвөлсөн нийт 70 гаруй соёлын биет болон биет бус өв өвлөн уламжлагчдыг нээн илрүүлж, авьяасыг хөгжүүлэн, сурталчилан таниулж, улсын өв уламжлагчийн бүртгэлд бүртгээд байна



Соёлын төвийн Номын сан нь 2002 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд 2013 оноос эхлэн улсын хэмжээний номын сангийн нэгдсэн программаар үйл ажиллагаагаа бүртгэн явуулж эхэлсэн. Харьяа яамруу программын тайланг хагас бүтэн жилээр хянауулан ажилладаг бөгөөд нийт 215 гадаад, 1542 монгол нийт 1757 номтой жилд дунджаар 1436 иргэнд давхардсан тоогоор үйлчилж, дунджаар 2428 ном давхардсан тоогоор олгон ажиллаж байна. 2022 оны 9 дүгээр сард Соёлын яамны санхүүжилтээр 500,000 төгрөгнд хүүхдийн ном худалдан авч номын фондоо баяжуулаад байна.

2010 оноос хойш аймгийн хэмжээний шилдэг уншигчдын уралдаанаас нийт 9 сурагчийг тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтнээр шалгаруулсан. Мөн нийт иргэдийг номтой нөхөрлүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор соёл олон түмний ажил, үзэсгэлэн, уралдаан тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

